



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/55

Мандалговь

“Монгол хьундай автоматив” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Их засварын хөдлөх хөрөнгийн их засвар үйлчилгээний батлагдсан зардлаас “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны автомашины засвар” шинэчлэлийн ажлыг “Монгол хьундай автоматив” ХХК-тай 6,264,500 (зургаан сая хоёр зуун жаран дөрвөн мянга таван зуу) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Гэрээнд заасан хугацаанд “Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны автомашины засвар” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Монгол хьундай автоматив” ХХК-ны гүйцэтгэх захирал (М.Энхбат)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ш.Энхсүх), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.ДОРЖБАТ



4820150120